

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2024 оны сарын өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Журам, загвар, маягтыг шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Жолоочийн даатгалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам”-ыг энэ тогтоолын нэгдүгээр хавсралтаар, “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний мэдүүлгийн маягт”-ыг хоёрдугаар хавсралтаар, “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний стандарт, загвар”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэ тогтоолоор баталсан журам, загвар, маягтыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3. Энэ тогтоолоор баталсан журам, загвар, маягт нь хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс эхлэн Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 211, 212 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ТООЦОХ ИТГЭЛЦҮҮР ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Жолоочийн даатгалын тухай хуулийн дагуу даатгуулагчийн төлөх хураамжийн хэмжээг тооцохтой холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцоход итгэлцүүр хэрэглэх

2.1. Жолоочийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүрүүдийг дараах байдлаар тогтооно. Үүнд:

2.1.1. Жолоочийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1-т заасан итгэлцүүр /цаашид T_1 итгэлцүүр гэх/-ийг энэ журмын нэгдүгээр хавсралтад заасны дагуу;

2.1.2. Жолоочийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.7-д заасан итгэлцүүр /цаашид T_2 итгэлцүүр гэх/-ийг энэ журмын 2 дугаар хавсралтад заасны дагуу;

2.1.3. Жолоочийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4-т заасан итгэлцүүр /цаашид T_3 итгэлцүүр гэх/-ийг энэ журмын 3 дугаар хавсралтад заасны дагуу;

2.1.4. Жолоочийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.9-д заасан итгэлцүүр /цаашид T_4 итгэлцүүр гэх/-ийг энэ журмын 4 дүгээр хавсралтад заасны дагуу;

2.1.5. Жолоочийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.8-д заасан итгэлцүүр /цаашид Θ_1 итгэлцүүр гэх/-ийг энэ журмын 5 дугаар хавсралтад заасны дагуу;

2.1.6. Жолоочийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5-д заасан итгэлцүүр /цаашид Θ_2 итгэлцүүр гэх/-ийг энэ журмын 6 дугаар хавсралтад заасны дагуу;

2.1.7. Жолоочийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6-д заасан итгэлцүүр /цаашид J_1 итгэлцүүр гэх/-ийг энэ журмын 7 дугаар хавсралтад заасны дагуу;

2.1.8. Жолоочийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2-т заасан итгэлцүүр /цаашид J_2 итгэлцүүр гэх/-ийг энэ журмын 8 дугаар хавсралтад заасны дагуу;

2.1.9. Жолоочийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3-т заасан итгэлцүүр /цаашид J_3 итгэлцүүр гэх/-ийг энэ журмын 9 дүгээр хавсралтад заасны дагуу.

2.2. Жолоочийн даатгалын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан суурь хураамж /цаашид X_0 гэх/ болон энэ журмын 2.1-д заасан итгэлцүүрүүдийг хэрэглэн дараах хүснэгтэд тусгасан томьёоны дагуу жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцно.

	Даатгалын хураамжийн төрөл	Даатгалын хураамжийг тооцох томьёо
2.2.1.	Мэргэшсэн болон C, D ангиллын жолоочийн даатгалын хураамж	$X = X_0 \times J_2 \times J_3 \times T_3 \times \Theta_2$
2.2.2.	Хувь хүний нэр дээр бүртгэлтэй тээврийн хэрэгслийн жолоочийн даатгалын хураамж	$X = X_0 \times T_1 \times T_2 \times T_3 \times T_4 \times \Theta_1 \times \Theta_2 \times J_1 \times J_2 \times J_3$
2.2.3.	Хуулийн этгээдийн нэр дээр бүртгэлтэй тээврийн хэрэгслийн жолоочийн даатгалын хураамж	$X = X_0 \times T_1 \times T_2 \times T_3 \times T_4 \times \Theta_1 \times \Theta_2 \times J_1 \times J_2 \times J_3$
2.2.4.	Дамжин өнгөрөх болон түр хугацаагаар Монгол Улсын нутаг дэвсгэрт орж ирж байгаа тээврийн хэрэгслийн жолоочийн даатгалын хураамж	$X = X_0 \times T_1 \times T_2 \times T_3 \times T_4 \times \Theta_1 \times \Theta_2 \times J_1 \times J_2 \times J_3$

“Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам”-ын нэгдүгээр хавсралт

T₁ итгэлцүүрийг тогтоох

1. T₁ итгэлцүүрийг тогтоохдоо тээврийн хэрэгслийн гэрчилгээнд бичигдсэн улсын бүртгэлийн дугаарт хамаарах газар нутгийн байршлыг үндэслэх ба дараах хэмжээтэй байна.

№	Тээврийн хэрэгслийг ашиглах газар нутгийн байршил	T ₁
1	Улаанбаатар хот	1.4
2	Дархан-Уул	1.2
3	Орхон	1.2
4	Дорнод	1.0
5	Дорноговь	1.0
6	Өмнөговь	1.0
7	Төв	1.0
8	Хэнтий	1.0
9	Сэлэнгэ	1.0
10	Баян-Өлгий	1.0
11	Баянхонгор	1.0
12	Булган	1.0
13	Говь-Алтай	1.0
14	Говьсүмбэр	1.0
15	Дундговь	1.0
16	Завхан	1.0
17	Өвөрхангай	1.0
18	Сүхбаатар	1.0
19	Архангай	1.0
20	Увс	1.0
21	Ховд	1.0
22	Хөвсгөл	1.0
23	Дамжин өнгөрөх болон түр хугацаагаар Монгол Улсын нутаг дэвсгэрт орж ирж байгаа тээврийн хэрэгсэл	1.5

Т₂ итгэлцүүрийг тогтоох

1. Т₂ итгэлцүүрийг тогтоохдоо тээврийн хэрэгслийн ашиглалт, хүрээлэн буй орчинд учруулж болзошгүй эрсдэлт байдалд нийцүүлэн тогтоох зарчмыг баримтлах ба энэхүү журамд заасан үндсэн хүснэгт болон тээврийн ашиглалтаас хамаарсан тусгай нөхцөлийг харгалзан дараах томъёогоор тооцно.

$$T_2 \text{ итгэлцүүр} = (\text{Үндсэн хүснэгтийн утга}) \times (\text{Тусгай нөхцөлийн утга})$$

2. Т₂ итгэлцүүрийн үндсэн хүснэгт:

Тээврийн хэрэгслийн ангилал, даац, зорчигчийн суудлын тоо, хөдөлгүүрийн хүчин чадал		T ₂ (үндсэн хүснэгт)
В ангилал <i>Хөдөлгүүрийн багтаамж /см³/</i>	-1000 хүртэл	0.9
	-1001-2000	1.0
	-2001-3000	1.1
	-3001-4000	1.2
	-4001-с дээш	1.3
С ангилал <i>Тээврийн хэрэгслийн даац</i>	-8 тонн хүртэлх даацтай	1.0
	-8 болон түүнээс дээш тоннын даацтай	1.3
Д ангилал <i>Суудлын тоо</i>	-16 хүртэлх зорчигчийн суудалтай	1.0
	-16 болон түүнээс дээш зорчигчийн суудалтай	1.3
Байгаль орчинд ээлтэй цахилгаан болон бусад тусгайлсан хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэл	Бүх ангиллын тээврийн хэрэгсэл ба хөдөлгүүрийн хүчин чадал үл хамаарна	0.8

3. Тээврийн хэрэгслийн ашиглалтаас хамаарсан тусгай нөхцөлийн утга нь тээврийн хэрэгслийн үйлдвэрлэгдсэн он, жолооны хүрдний байрлал, өмнөх жилд туулсан замын уртад харгалзах утгуудын арифметик дундажтай тэнцүү байх ба дараах томъёогоор тооцно.

$$\text{Тусгай нөхцөлийн утга} = (A_1 + A_2 + A_3) / 3$$

Томьёолол	Тээврийн хэрэгслийн ашиглалт	төрөл	T ₂ (тусгай нөхцөл)
A ₁	Үйлдвэрлэгдсэн он	Гэрээ байгуулах үеэс 10-с дээш жилийн өмнө үйлдвэрлэгдсэн	1.3
		Гэрээ байгуулах үеэс 7-с 10 хүртэлх жилийн өмнө үйлдвэрлэгдсэн	1.2
		Гэрээ байгуулах үеэс 5-с 6 хүртэлх жилийн өмнө үйлдвэрлэгдсэн	1.1
		Гэрээ байгуулах үеэс 5 хүртэлх жилийн дотор үйлдвэрлэгдсэн	1.0
A ₂	Жолооны хүрдний байрлал	Баруун	1.1
		Зүүн	1.0

A ₃	Жолоочийн даатгалын мэдээллийн санд бүртгэгдсэн хамгийн сүүлийн 1 жилийн туулсан замын урт <i>*Тайлбар: Хилээр анх нэвтэрсэн тээврийн хэрэгслийн A₃=1.0 байна</i>	1-5000 хүртэлх км	1.0
		5001-10000 хүртэлх км	1.1
		10001 болон түүнээс дээш км	1.2

4. Гадаад улсад бүртгэлтэй буюу дамжин өнгөрөх болон түр хугацаагаар Монгол Улсын нутаг дэвсгэрт орж ирж байгаа тээврийн хэрэгслийн T₂ итгэлцүүр дараах хэмжээтэй байна:

Тээврийн хэрэгслийн ангилал, даац, зорчигчийн суудлын тоо, хөдөлгүүрийн хүчин чадал		T ₂
<u>В ангилал</u> <i>Хөдөлгүүрийн багтаамж /см³/</i>	-1000 хүртэл	1.0
	-1001-2000	1.3
	-2001-3000	1.6
	-3001-4000	1.9
	-4001-с дээш	2.1
<u>С ангилал</u> <i>Тээврийн хэрэгслийн даац</i>	-10 тонн хүртэлх даацтай	1.0
	-10-аас 20 хүртэлх тоннын даацтай	1.5
	-20-иос 40 хүртэлх тоннын даацтай	2.0
	-40 болон түүнээс дээш тоннын даацтай	3.0
<u>Д ангилал</u> <i>Суудлын тоо</i>	-15 хүртэлх зорчигчийн суудалтай	1.0
	-16-аас 33 хүртэлх зорчигчийн суудалтай	2.0
	-33 болон түүнээс дээш зорчигчийн суудалтай	3.0

5. T₂ итгэлцүүрийг тогтоохдоо Гадаад улсад бүртгэлтэй буюу дамжин өнгөрөх болон түр хугацаагаар Монгол Улсын нутаг дэвсгэрт орж ирж байгаа тээврийн хэрэгслээс бусад В, С болон D ангиллын тээврийн хэрэгслийн жолоочийн даатгалд энэхүү журмын 2 дугаар хавсралтын 2 болон 3 дахь хэсэгт заасныг үндэслэнэ.

6.“А” болон “механизм” ангиллын тээврийн хэрэгслийн хувьд T₂=1 байхаар тооцно.

--ooOoo--

T₃ итгэлцүүрийг тогтоох

1. Монгол Улсад бүртгэлтэй тээврийн хэрэгслийн жолоочийн даатгалын гэрээний хугацаа /1 жил/-аас хамаарах итгэлцүүр $T_3=1$ байна.
2. Гадаад улсад бүртгэлтэй буюу дамжин өнгөрөх болон түр хугацаагаар Монгол Улсын нутаг дэвсгэрт орж ирж байгаа тээврийн хэрэгслийн жолоочийн даатгалын гэрээний хугацаанаас хамаарах итгэлцүүр T_3 нь дараах хэмжээтэй байна:

Гадаад улсад бүртгэлтэй тээврийн хэрэгслийн жолоочийн даатгалын гэрээний хугацаа	T_3
2 сар хүртэл	1.3
2 сараас 3 сар хүртэл	1.6
3 сараас 4 сар хүртэл	1.9
4 сараас 5 сар хүртэл	2.1
5 сараас 6 сар хүртэл	2.4

--ooOoo--

T₄ итгэлцүүрийг тогтоох

1.Тээврийн хэрэгсэл нь чиргүүтэй эсэхээс хамааран T₄ итгэлцүүр дараах хэмжээтэй байна:

Чиргүүлтэй эсэх	T ₄
Чиргүүлгүй	1.0
Чиргүүлтэй	1.2

--ooOoo--

Ө₁ итгэлцүүрийг тогтоох

1.Ө₁ итгэлцүүр нь дараах хэмжээтэй байна:

Тээврийн хэрэгслийн зориулалт	Ө ₁
Хувь хүний нэр дээр байгуулсан даатгалын гэрээ	
Суудлын	1.00
Автобус	1.10
Ачаа	1.10
Механизм	1.05
Мотоцикл	1.00
Хуулийн этгээдийн нэр дээр байгуулсан даатгалын гэрээ	
Суудлын	1.40
Автобус	1.60
Ачаа	1.60
Механизм	1.50
Мотоцикл	1.40
Банк болон банк бус санхүүгийн байгууллагын барьцаалбарт буй тээврийн хэрэгслийн эзэмшигч нь хувь хүн байх даатгалын гэрээ	
Суудлын	1.10
Автобус	1.20
Ачаа	1.20
Механизм	1.15
Мотоцикл	1.10

2.Тээврийн хэрэгслийн зориулалтыг тогтоохдоо тээврийн хэрэгслийн гэрчилгээнд дурдсан өмчлөгчийн мэдээллийг үндэслэнэ.

Ө₂ итгэлцүүрийг тогтоох

1. Даатгуулагч нь даатгалын хураамжийн хэмжээг бууруулах эсхүл даатгалын нөхөн төлбөрийг нэмэгдүүлэхэд нөлөөлөхүйц худал мэдүүлэг санаатай өгсөн нь тогтоогдвол тус даатгалын гэрээ дууссаны дараа байгуулах гэрээний даатгалын хураамжийн Θ_2 итгэлцүүр 1.3-тай тэнцүү байна. Бусад тохиолдолд $\Theta_2=1.0$ байна.

--ooOoo--

Ж₁ итгэлцүүрийг тогтоох

1. Ж₁ итгэлцүүр нь дараах хэмжээтэй байна:

Тээврийн хэрэгсэл ашиглах жолоочийн тоог хязгаарласан эсэх	Ж ₁
Хувь хүний нэр дээр байгуулсан даатгалын гэрээ	
Зөвхөн тээврийн хэрэгслийн өмчлөгч даатгуулсан, мөн даатгалын гэрээнд 1 жолоочийн нэр дурдсан	1.00
Тээврийн хэрэгслийн өмчлөгчөөс гадна даатгалын гэрээнд 2-4 жолоочийн нэр дурдсан	1.10
Тээврийн хэрэгслийн өмчлөгчөөс гадна даатгалын гэрээнд 5 буюу түүнээс дээш жолоочийн нэр дурдсан	1.30
Тээврийн хэрэгслийн өмчлөгчөөс гадна даатгалын гэрээнд жолоочийн тоог хязгаарлаагүй	2.30
Хуулийн этгээдийн нэр дээр байгуулсан даатгалын гэрээ	
Банк болон банк бус санхүүгийн байгууллагын барьцаалбарт буй тээврийн хэрэгслийн эзэмшигч нь хувь хүн байх даатгалын гэрээнд 1-4 жолоочийн нэр дурдсан	1.30
Банк болон банк бус санхүүгийн байгууллагын барьцаалбарт буй тээврийн хэрэгслийн эзэмшигч нь хувь хүн байх даатгалын гэрээнд 5 буюу түүнээс дээш жолоочийн нэр дурдсан	1.50
Банк болон банк бус санхүүгийн байгууллагын барьцаалбарт буй тээврийн хэрэгслийн эзэмшигч нь хувь хүн байх даатгалын гэрээнд жолоочийн тоог хязгаарлаагүй	2.45
Нийтийн зорчигч, тээврийн үйлчилгээнд ашиглагдаж буй тээврийн хэрэгслийн хувьд даатгалын гэрээнд 1-3 жолоочийн нэр дурдсан	1.80
Нийтийн зорчигч, тээврийн үйлчилгээнд ашиглагдаж буй тээврийн хэрэгслийн хувьд даатгалын гэрээнд 4 буюу түүнээс дээш жолоочийн нэр дурдсан	2.00
Нийтийн зорчигч, тээврийн үйлчилгээнд ашиглагдаж буй тээврийн хэрэгслийн хувьд даатгалын гэрээнд жолоочийн тоог хязгаарлаагүй	2.45
Бусад хуулийн этгээдийн нэр дээр байгуулсан даатгалын гэрээний хувьд даатгалын гэрээнд 1-3 жолоочийн нэр дурдсан	1.50
Бусад хуулийн этгээдийн нэр дээр байгуулсан даатгалын гэрээний хувьд 4 буюу түүнээс дээш жолоочийн нэр дурдсан	1.80
Бусад хуулийн этгээдийн нэр дээр байгуулсан даатгалын гэрээний хувьд даатгалын гэрээнд жолоочийн тоог хязгаарлаагүй	2.45

“Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам”-ын наймдугаар хавсралт

Ж₂ итгэлцүүрийг тогтоох

1. Ж₂ итгэлцүүрийг даатгалын гэрээ байгуулахаас өмнөх жилийн эцсийн байдлаар буюу өмнөх 1 жилд даатгуулагч/жолоочийн буруугаас үүссэн даатгалын тохиолдлын тоо, зам, тээврийн осол, зөрчлийн төрөл, олгосон нөхөн төлбөрийн хэмжээнээс хамаарах ба жолоочийн хариуцлагатай байдлыг илтгэх зарчмыг баримталж тогтооно.

2. Даатгуулагч/жолоочийн Ж₂ итгэлцүүрийг энэхүү журамд заасан Ж₂ итгэлцүүрийн үндсэн хүснэгтийн утга болон нэгдүгээр тусгай нөхцөлийг харгалзан, дараах томъёогоор тооцно.

$$Ж_2 = (\text{Үндсэн хүснэгт}) + (\text{Тусгай нөхцөл})$$

2.1. Үндсэн хүснэгт: Даатгалын тохиолдлын тоо, олгосон нөхөн төлбөрийн хэмжээг өссөн дүнгээр тооцох ба даатгуулагчийн гэрээ байгуулж буй хугацаанаас өмнөх Ж₂ итгэлцүүрийн утгыг дараах үндсэн хүснэгтэд заасан хэмжээгээр тооцно. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээ анх байгуулж байгаа даатгуулагчийн Ж₂ итгэлцүүрийн үндсэн хүснэгтийн Ж₂ утга 1.0-тэй тэнцүү байна.

Даатгуулагчийн Ж ₂ * итгэлцүүрийн утга	Ж ₂ итгэлцүүрийн үндсэн хүснэгтийн утга												
	Нөхөн төлбөр олгоогүй	1 удаа олгосон нөхөн төлбөрийн нийт хэмжээ /мян.төг/				2 удаа олгосон нөхөн төлбөрийн нийт хэмжээ /мян.төг/				3 болон түүнээс дээш удаа олгосон нөхөн төлбөрийн нийт хэмжээ /мян.төг/			
		300.0 хүртэлх	1000.0 хүртэлх	2000.0 хүртэлх	2000.0-ээс дээш	300.0 хүртэлх	1000.0 хүртэлх	2000.0 хүртэлх	2000.0-ээс дээш	300.0 хүртэлх	1000.0 хүртэлх	2000.0 хүртэлх	2000.0-ээс дээш
2.45	2.30	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45
2.30	1.55	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45
1.55	1.40	2.30	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45
1.40	1.00	1.55	2.30	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45
1.00	0.95	1.40	1.55	2.30	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45
0.95	0.90	1.00	1.40	1.55	2.30	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45
0.90	0.85	0.95	1.00	1.40	1.55	2.30	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45
0.85	0.80	0.90	0.95	1.00	1.40	1.55	2.30	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45
0.80	0.75	0.85	0.90	0.95	1.00	1.40	1.55	2.30	2.45	2.45	2.45	2.45	2.45
0.75	0.70	0.80	0.85	0.90	0.95	1.00	1.40	1.55	2.30	2.45	2.45	2.45	2.45
0.70	0.65	0.75	0.80	0.85	0.90	0.95	1.00	1.40	1.55	2.30	2.45	2.45	2.45
0.65	0.60	0.70	0.75	0.80	0.85	0.90	0.95	1.00	1.40	1.55	2.30	2.45	2.45
0.60	0.55	0.65	0.70	0.75	0.80	0.85	0.90	0.95	1.00	1.40	1.55	2.30	2.45
0.55	0.50	0.60	0.65	0.70	0.75	0.80	0.85	0.90	0.95	1.00	1.40	1.55	2.30
0.50	0.50	0.55	0.60	0.65	0.70	0.75	0.80	0.85	0.90	0.95	1.00	1.40	1.55

*Үндсэн хүснэгтийн Ж₂ утга

2.2. Тусгай нөхцөл: Даатгуулагч/жолооч нь даатгалын гэрээ байгуулахаас өмнөх жилийн эцсийн байдлаар буюу өмнөх 1 жилд Монгол Улсын хууль тогтоомжид заасан замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх дараах дүрмийг зөрчин даатгалын тохиолдол гаргасан бол дээрх үндсэн хүснэгтийн итгэлцүүрийн утгыг тухайн гэрээний хугацаанд 0.4 функтээр нэмэгдүүлэн тооцно.

2.2.1. согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ зам тээврийн осол гаргасан;

2.2.2. замын хөдөлгөөний хурдны хязгаарлалтыг хэтрүүлсний улмаас зам тээврийн осол гаргасан;

2.2.3. замын хөдөлгөөн зохион байгуулах техник хэрэгсэл, замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, зохицуулагчийн зааврыг зөрчин зам тээврийн осол гаргасан;

2.2.4. замын хөдөлгөөний дүрэмд хориглосон нөхцөлөөр жолооч урсгал сөрсөн үедээ зам тээврийн осол гаргасан.

2.3. Даатгалын гэрээнд 2 ба түүнээс дээш жолоочийн нэр дурдсан тохиолдолд тэдгээрийн хамгийн өндөр итгэлцүүрийг J_2 гэж тооцно.

2.4. Даатгалын гэрээ байгуулахаас өмнөх жилийн эцсийн байдлаар буюу өмнөх 1 жилд даатгалын тохиолдол гаргаагүй бол даатгалын гэрээнд нэр дурдагдсан жолооч бүрийн J_2 итгэлцүүрийн утга буурах зарчмыг баримтална.

2.5. Даатгалын гэрээ нь хувь хүний нэр дээр байгуулагдсан даатгалын гэрээнд тээврийн хэрэгслийн жолоочийн тоог хязгаарлаагүй тохиолдолд $J_2=2.3$ байна.

2.6. Даатгалын гэрээ нь хуулийн этгээдийн нэр дээр байгуулагдсан даатгалын гэрээнд тээврийн хэрэгслийн жолоочийн тоог хязгаарлаагүй тохиолдолд $J_2=2.45$ байна.

2.7. Даатгалын гэрээнд жолоочийн тоо хязгаарлаагүй тохиолдолд даатгалын гэрээ байгуулахаас өмнөх жилийн эцсийн байдлаар буюу өмнөх 1 жилд тухайн тээврийн хэрэгслийг жолоодож явсан этгээд энэ журмын 8 дугаар хавсралтын 2.2 дахь хэсэгт заасан зөрчлөөр даатгалын тохиолдол гаргасан бол J_2 итгэлцүүрийг тухайн гэрээний хугацаанд 0.4 функтээр нэмэгдүүлэн тооцно.

2.8. Тээврийн хэрэгслийн өмчлөгч даатгалын гэрээ байгуулаагүй жилд үндсэн хүснэгтийн J_2 -ийн утга өсөх зарчмыг баримтлах буюу нэг удаа даатгалын тохиолдол гаргаж, гурван зуун мянга хүртэлх нөхөн төлбөр авсан гэж үзнэ.

--ooOoo--

Ж3 итгэлцүүрийг тогтоох

1. Даатгуулагч/жолоочийн Ж3 итгэлцүүрийг дараах хүснэгтэд үндэслэн тогтооно:

Туршлага		25 хүртэлх насны	25-40 насны	41-60 насны	61 болон түүнээс дээш насны
Даатгуулагчийн нас					
5 жилийн турш даатгалын гэрээ байгуулсан*	5 жил хүртэлх туршлагатай	1.40	1.35	1.25	1.40
	5-10 жил хүртэлх туршлагатай	1.35	1.25	1.15	1.15
	10-15 жил хүртэлх туршлагатай	-	1.15	1.15	1.15
	15 болон түүнээс дээш жилийн туршлагатай	-	1.10	1.10	1.10
6-10 хүртэл жилийн турш даатгалын гэрээ байгуулсан*	6 -10 жил хүртэлх туршлагатай	1.20	1.15	1.10	1.10
	10-15 жил хүртэлх туршлагатай	-	1.10	1.00	1.05
	15 болон түүнээс дээш жилийн туршлагатай	-	1.05	1.00	1.00
10-с дээш жилийн турш даатгалын гэрээ байгуулсан*	10-15 жил хүртэлх туршлагатай	-	1.00	0.95	1.00
	15 болон түүнээс дээш жилийн туршлагатай	-	1.00	0.90	1.00

*Тухайн жилүүдэд даатгуулагч/жолоочийн нэр дурдагдсан тохиолдолд даатгалын гэрээ байгуулсан гэсэн нөхцөлд хамааруулна.

2. Даатгалын гэрээнд тээврийн хэрэгслийн жолоочийн тоог хязгаарлаагүй тохиолдолд Ж₃=1.4 байна.

3. Даатгалын гэрээнд 2 ба түүнээс дээш жолоочийн нэр дурдагдсан бол тэдгээрийн хамгийн өндөр Ж3 итгэлцүүрийн утгаар даатгалын хураамжийг тооцно.

--ooOoo--

**ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН АЛБАН ЖУРМЫН
ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ МЭДҮҮЛГИЙН МАЯГТ**

Гэрээний дугаар:

Даатгалын компани: /Даатгагчийн нэр/

Борлуулалтын суваг:

Даатгалын зуучлагч компани /Даатгалын зуучлагчийн нэр/

Даатгалын төлөөлөгч /Даатгалын төлөөлөгчийн
нэр, иргэний бүртгэлийн дугаар/

/Даатгуулагчийн бөглөх хэсэг/

Тээврийн хэрэгслийн улсын дугаар:

Даатгалын гэрээнд жолоочийн тоо хязгаарлах эсэх: (Тийм/Үгүй)

*анхаарах**: үгүй буюу жолоочийн тоо хязгаарлаагүй нөхцөлд даатгуулагчийн хураамжийн хэмжээ боломжит хамгийн өндөр хэмжээнд тогтоогдоно

Тийм буюу жолоочийн тоо хязгаарлах нөхцөлд дараах мэдээллийг бөглөнө.

Дараах нэр дурдсан жолооч нар тээврийн хэрэгслийг жолоодно: /гэрээнд хэдэн ч жолоочийн нэр дурдаж болно/

№	Иргэний бүртгэлийн дугаар	Овог	Нэр	Холбоо барих утасны дугаар
1				
2				
3				
4				
...				

**Тайлбар:* Даатгалын гэрээнд нэр дурдагдсан жолооч бүрийг даатгуулагч гэж үзнэ.

1.Тээврийн хэрэгслийн мэдээлэл: /Доорх мэдээлэл нь төрийн үйлчилгээний нэгдсэн систем болон Жолоочийн даатгалын мэдээллийн сангаас татагдана /

Улсын дугаар:

Арлын дугаар:

Үйлдвэр:

Үйлдвэрлэгдсэн огноо:

Марк:

Хөдөлгүүрийн багтаамж (см³):

Тээврийн хэрэгслийн ангилал:

Тээврийн хэрэгслийн төрөл: /Автобус, ачаа, суудал, механизм, чиргүүл, мотоцикл, тусгай/

Суудлын тоо:

Ачааны даац (кг):

Өнгө:

Жолооны хүрд: (Баруун/Зүүн)

Импорлогдсон огноо:

Туулсан зам /км/: Хилээр нэвтрэн орж ирсэн үеийн явсан гүйлт км, гэрээ байгуулахаас өмнөх жилийн эцсийн байдлаарх буюу тухайн жилд тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношлогооны үеийн тэмдэглэгдсэн гүйлт км

Чиргүүл: (Тийм/Үгүй)

2. Даатгалын гэрээний хугацаа:

Эхлэх хугацаа: 20__-__-__ __:__:__ Дуусах хугацаа: 20__-__-__ __:__:__

(Он, сар, өдөр, цаг, минут)

(Он, сар, өдөр, цаг, минут)

/Монгол Улсад бүртгэлтэй тээврийн хэрэгслийн жолоочийн даатгалын гэрээний хугацаа 1 жил байна/

3. Тээврийн хэрэгслийн өмчлөгчийн мэдээлэл: /Доорх мэдээлэл нь төрийн үйлчилгээний нэгдсэн систем болон Жолоочийн даатгалын мэдээллийн сангаас татагдана /

(Хувь хүн/Хуулийн этгээд/Банк болон банк бус санхүүгийн байгууллагын барьцаалбар хэлбэрээр)

Хувь хүн:

Даатгуулагчийн эцэг/эх, нэр:

Иргэний бүртгэлийн дугаар:

Жолооны үнэмлэхийн дугаар:

Мэргэшсэн жолоочийн үнэмлэх: (үнэмлэхийн дугаар)

Жолооны үнэмлэхийн ангилал:

Жолооны үнэмлэхийн хүчинтэй хугацаа: ... он ... сар ... өдөр

Жолооны туршлага: (жилээр)

Ж₂ итгэлцүүрийн үндсэн хүснэгтийн утга: (Даатгуулагчийн гэрээ байгуулах үеийн)

Нөхөн төлбөр: ..., (Өмнөх нэг жилийн хугацаанд авсан нөхөн төлбөрийн тоо, хэмжээ)

Хуулийн этгээд/ Банк болон банк бус санхүүгийн байгууллагын барьцаалбар хэлбэрээр:

Байгууллагын нэр: /ТХ-ийг өмчлөгч хуулийн этгээдийн нэр/

Байгууллагын регистрийн дугаар:

4.Тээврийн хэрэгслийг жолоодох зөвшөөрөгдсөн жолоочийн мэдээлэл: /Доорх мэдээлэл нь төрийн үйлчилгээний нэгдсэн систем болон Жолоочийн даатгалын мэдээллийн сангаас татагдана /

Жолоочийн тоог хязгаарлахгүй / хязгаарлаж, дараах нэр дурдсан жолооч нар жолоодно:

(доогуур нь зурах)

№	Иргэний бүртгэлийн дугаар	Эцэг/эх	Нэр	Жолооны үнэмлэхийн дугаар	Жолооны туршлага (жилээр)	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээ байгуулсан туршлага	Ж ₂ итгэлцүүрийн үндсэн хүснэгтийн утга	Гэрээ байгуулахаас өмнөх жилийн эцсийн байдлаарх даатгалын тохиолдол гаргасан тухай мэдээлэл		
								Тоо	Хэмжээ	Зам, тээврийн ослын зөрчлийн төрөл **
1										
2										
3										
4										
*										

***Тайлбар:** Тээврийн хэрэгслийг жолоодох жолоочийн тоо 4-өөс дээш байх тохиолдолд даатгуулагчийн мэдүүлгийн маягтад тусад нь хүснэгт хийж хавсаргаж болно.

****Тайлбар:** “Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам”-д заасан зам тээврийн ослын зөрчилийн дугаарыг тэмдэглэнэ. Тухайлбал, 2.2.1 гэх мэт.

5. Даатгалын хураамж: (Даатгагч нөхөж бичнэ)

Мэргэшсэн болон C, D ангиллын жолоочийн даатгалын хураамж:

$$X = X_0 \times Ж_2 \times Ж_3 \times T_3 \times \Theta_2$$

Хувь хүний нэр дээр бүртгэлтэй тээврийн хэрэгслийн жолоочийн даатгалын хураамж:

$$X = X_0 \times T_1 \times T_2 \times T_3 \times T_4 \times \Theta_1 \times \Theta_2 \times Ж_1 \times Ж_2 \times Ж_3$$

Хуулийн этгээдийн нэр дээр бүртгэлтэй тээврийн хэрэгслийн жолоочийн даатгалын хураамж:

$$X = X_0 \times T_1 \times T_2 \times T_3 \times T_4 \times \Theta_1 \times \Theta_2 \times Ж_1 \times Ж_2 \times Ж_3$$

Дамжин өнгөрөх болон түр хугацаагаар Монгол улсын нутаг дэвсгэрт орж ирж байгаа тээврийн хэрэгслийн жолоочийн даатгалын хураамж:

$$X = X_0 \times T_1 \times T_2 \times T_3 \times T_4 \times \Theta_1 \times \Theta_2 \times Ж_1 \times Ж_2 \times Ж_3$$

Суурь хураамж - X_0	Итгэлцүүрийн нэр	Итгэлцүүрийн хэмжээ	Хураамжийн дүн X
$X_0 = \dots\dots\dots$	Тээврийн хэрэгслийг ашиглах газар нутгийн байршлаас хамаарах итгэлцүүр T_1	$T_1 = \dots\dots\dots$	$X = \dots\dots\dots\dots\dots\dots$

Тээврийн хэрэгслийн зориулалт ба тээврийн хэрэгслийн ашиглалтаас хамаарах итгэлцүүр T_2	$T_2 = \dots\dots$
Даатгалын гэрээний хугацаанаас хамаарах итгэлцүүр T_3	$T_3 = \dots\dots$
Чиргүүлтэй эсэхээс хамаарах итгэлцүүр T_4	$T_4 = \dots\dots$
Тээврийн хэрэгслийн зориулалт, өмчлөлийн хэлбэрээс хамаарах итгэлцүүр Θ_1	$\Theta_1 = \dots\dots$
Даатгалын хураамжийн хэмжээг журамд зааснаас доогуур тогтоосон, эсхүл нөхөн төлбөрийг нэмэгдүүлэхэд нөлөөлөхүйц худал мэдүүлэг санаатай өгсөн эсэхээс хамаарах итгэлцүүр Θ_2	$\Theta_2 = \dots\dots$
Тээврийн хэрэгслийг ашиглах жолоочийн тооноос хамаарах итгэлцүүр J_1	$J_1 = \dots\dots$
Өмнөх гэрээний хугацаанд даатгуулагчийн буруугаас үүссэн даатгалын тохиолдол /зам тээврийн ослын зөрчил/-ын тоо, олгосон нөхөн төлбөрийн хэмжээнээс хамаарах итгэлцүүр J_2	$J_2 = \dots\dots$
Даатгуулагчийн нас, автотээврийн хэрэгсэл жолоодох туршлагаас хамаарах итгэлцүүр J_3	$J_3 = \dots\dots$

Хэвлэсэн огноо: 20__-__-__ __:__:__

Даатгуулагчийг төлөөлж:(.....)

Даатгагчийг төлөөлж:(.....)

(гарын үсэг)

(нэр)

“Мэргэшсэн болон С, D ангиллын жолоочийн даатгалыг хийлгэх үү: (Тийм/Үгүй)

Даатгалын гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж, хураамжийн буцаалт хийх тохиолдолд мөнгө хүлээн авах хэлбэр: Бэлэн мөнгөөр; Дансаар;

Хэрэв дансаар хүлээн авах бол: Банкны нэр: ... Дансны дугаар: ... Данс эзэмшигчийн овог, нэр: ...

Гэрээний мэдүүлэг болон даатгалын гэрээг тус бүр 2 хувь үйлдэж, 1 хувийг даатгуулагчид өгч, 1 хувь нь даатгагчид үлдэнэ.

**ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН АЛБАН ЖУРМЫН
ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ СТАНДАРТ, ЗАГВАР**

Дугаар ...

Энэхүү гэрээг нэг талаас _____

(иргэний овог, нэр)

(хуулийн этгээдийн нэр)

_____ /цаашид “даатгуулагч” гэх/, нөгөө талаас _____ ХХК-(иргэний
бүртгэлийн дугаар) (даатгалын компанийн нэр)

ийг төлөөлж _____ ажилтай _____ /цаашид “даатгагч” гэх/ нар

(албан тушаал)

(овог, нэр)

Жолоочийн даатгалын тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжийг үндэслэн байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээ нь даатгуулагч даатгалын зүйлээ даатгагчид даатгуулах, даатгагч нь гэрээнд заасан эрсдэл үүссэн тохиолдолд нөхөн төлбөр олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Даатгуулагч нь энэхүү даатгалын гэрээг байгуулахаас өмнө батлагдсан маягтын дагуу мэдүүлэг бөглөж даатгагчид өгнө.

1.3. Даатгалын мэдүүлэг нь гэрээний салшгүй хэсэг болно.

1.4. Даатгагч нь даатгуулагчид Жолоочийн даатгалын тухай хууль, энэ гэрээгээр талуудын хүлээх эрх, үүргийг бүрэн тайлбарлан танилцуулж, хоёр тал харилцан хүлээн зөвшөөрснийг гэрчилж энэ гэрээнд гарын үсэг зурна.

1.5. Жолоочийн даатгалын мэдээллийн сангаас олгож буй 14 орон бүхий дугаар нь даатгалын баталгаа болно.

Хоёр. Даатгалын зүйл

2.1. Энэхүү гэрээний даатгалын зүйл нь жолооч замын хөдөлгөөнд оролцох үедээ бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учруулж болзошгүй хохирлыг нөхөн төлөх зорилготой бусдын өмнө хүлээх хариуцлага байна.

Гурав. Даатгалын эрсдэлийн төрөл

3.1. Даатгуулагч нь дараах төрлийн эрсдэлийг даатгуулна. Үүнд:

3.1.1.жолооч нь автотээврийнхэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцох үедээ бусдын амь насанд учруулсан хохирол;

3.1.2.жолооч нь автотээврийнхэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцох үедээ бусдын эрүүл мэндэд учруулсан хохирол;

3.1.3.жолооч нь автотээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцох үедээ бусдын эд хөрөнгөд учруулсан хохирол.

Дөрөв. Даатгалын үнэлгээ

4.1.Энэхүү гэрээний даатгалын үнэлгээний хэмжээ нь Жолоочийн даатгалын тухай хуулийн 9.1-д заасны дагуу дараах хэмжээтэй байна.

	Тээврийн хэрэгслийн ангилал	Даатгалын үнэлгээ буюу нэг удаа олгох нөхөн төлбөрийн дээд хэмжээ /төгрөг/	Даатгуулсан үнэлгээ, ангилалыг тэмдэглэх /+/
1	“А” ангиллын тээврийн хэрэгсэл	5 сая хүртэл	
2	“В” ангиллын тээврийн хэрэгсэл	5 сая хүртэл	
3	“С” ангиллын тээврийн хэрэгсэл	10 сая хүртэл	
4	“Д” ангиллын тээврийн хэрэгсэлд	10 сая хүртэл	
5	“Механизм” ангиллын тээврийн хэрэгсэл	5 сая хүртэл	

4.2.Мэргэшсэн жолооч болон С, D ангиллын тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцох жолоочийн даатгалын үнэлгээ нь тухайн даатгуулагчийн жолоодож замын хөдөлгөөнд оролцсон тээврийн хэрэгслийн ангиллын дагуу энэ журмын 4.1-д заасан хэмжээтэй байна.

Тав. Даатгалын хураамж

5.1.Даатгалын хураамжийн хэмжээг тогтоохдоо Жолоочийн даатгалын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан даатгалын суурь хураамжийн хэмжээг, тус хуулийн 11.1-д заасан итгэлцүүрээр нэмэгдүүлж буюу хорогдуулж тооцох буюу Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам”-ын дагуу тогтооно.

5.2.Даатгуулагч нь энэхүү гэрээний 5.1-д заасны дагуу тооцсон даатгалын хураамжийг даатгагчид төлнө.

5.3.Даатгалын хураамж бүрэн төлөгдсөн он, сар, өдөр, цаг, минутаас эхлэн даатгалын гэрээ хүчин төгөлдөр болно.

5.4.Даатгагч нь даатгалын хураамжаас гадна даатгалын гэрээний хуулбарыг даатгуулагчийн хүсэлтээр дахин олгох зардлаас бусад аливаа хэлбэрээр даатгуулагчаас шимтгэл, үйлчилгээний хөлс авахыг хориглоно.

Зургаа. Даатгалын гэрээний хугацаа, гэрээг цуцлах

6.1.Энэхүү гэрээ нь мэдүүлэгт заасан нэг жилийн хугацаанд хүчинтэй байна. Харин дамжин өнгөрөх болон түр хугацаагаар Монгол улсын нутаг дэвсгэрт орж ирж байгаа автотээврийн хэрэгслийн жолоочийн даатгалын гэрээний хугацаа нь даатгалын мэдүүлэгт заасан хугацаанд хүчинтэй байна.

6.2.Энэ гэрээний 11.1-т заасны дагуу гэрээг цуцалсан тохиолдолд гэрээний үлдэх хугацаатай тэнцэх хэмжээний даатгалын хураамжийг хувь тэнцүүлэн даатгуулагчид буцааж олгоно. Даатгалын гэрээний

хүчинтэй хугацаанд даатгагч хохирлын нөхөн төлбөр олгосон нөхцөлд даатгалын хураамжийн буцаалт хийгдэхгүй.

6.3. Даатгагч гэрээний хугацаа дуусахаас хуанлийн 14 хоногийн өмнө нөгөө талдаа мэдэгдэнэ.

6.4. Даатгагч нь энэ гэрээний 6.2-т заасан хураамжийн буцаан олголтыг жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний мэдүүлгийн маягтад бөглөсний дагуу ажлын 5 хоногийн дотор олгоно.

Долоо. Даатгагчийн эрх, үүрэг

7.1. Даатгагч дараах эрх эдэлнэ:

7.1.1. даатгагч нь нөхөн төлбөр буюу хохирлын хэмжээг тогтооход шаардлагатай мэдээллийг даатгуулагч, хохирогчоос шаардах;

7.1.2. жолоочийн даатгалын тухай хуулийн 16.2-т заасны дагуу даатгалын тохиолдол болсон газар нутгийн байршлыг харгалзан даатгагч, жолоочийн даатгалын сангийн төлөөлөгч нь энэхүү гэрээний 7.2.3-т заасан хугацааг хохирогч, даатгуулагчийн зөвшөөрлийн дагуу 10 хүртэл хоногоор сунгах;

7.1.3. даатгалын хохирлыг бодитой үнэлэхийг хохирол үнэлэгчээс шаардах;

7.2. Даатгагч дараах үүрэг хүлээнэ:

7.2.1. жолоочийн даатгалын тухай хууль тогтоомж, гэрээний нөхцөлийг даатгуулагчид танилцуулах;

7.2.2. даатгалын тохиолдол болсон үед нөхөн төлбөрийг хууль болон гэрээгээр тохиролцсон хугацаа, хэмжээнд олгох;

7.2.3. даатгуулагч өргөдөл гаргаснаас хойш 3 хоногийн дотор даатгалын тохиолдлыг шалгаж, даатгалын хохирол үнэлэгчийг томилох;

7.2.4. даатгагч даатгалын тохиолдлыг шалгах, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох, хохирлыг үнэлэхтэй холбогдон гарах зардлыг хариуцах;

7.2.5. даатгалын гэрээний хугацаанд бий болсон уг гэрээтэй холбоотой бүхий л мэдээллийг даатгуулагчид үнэ төлбөргүй гаргаж өгөх;

7.2.6. даатгалын гэрээний хугацааны талаар жилд 2 удаа мэдээлэл өгөх, дараагийн гэрээ байгуулахад орох өөрчлөлтийн талаар даатгуулагч хүсвэл урьдчилан зөвөлгөө өгөх;

7.2.7. даатгалын гэрээний мэдүүлгийн мэдээлэл, нөхөн төлбөр, даатгалын тохиолдол, даатгуулагчийн нэмэлт өөрчлөлтийн үнэн зөвийг шалгах, жолоочийн мэдээллийн санд тухай бүр үнэн зөв оруулах;

7.2.8. даатгалын гэрээнд жолоочийн тоо хязгаарлах эсхүл хязгаарлахгүй байх нь даатгалын хураамжийн хэмжээнд хэрхэн нөлөөлөх талаар мэдээллийг даатгалын гэрээ байгуулахаас өмнө даатгуулагчид заавал танилцуулах.

Найм. Даатгуулагчийн эрх, үүрэг

8.1. Даатгуулагч дараах эрх эдэлнэ:

8.1.1. даатгуулагч нь жолоочийн даатгалын гэрээний талаар мэдээлэл авах, даатгалын тохиолдол, нөхөн төлбөрийн мэдээллийг шалгуулах;

8.1.2. даатгалын тохиолдол болсон үед шуурхай албаны үйлчилгээ авах, гэрээний нөхцөлийн дагуу нөхөн төлбөр олгохыг даатгагчаас шаардах;

8.1.3. Жолоочийн даатгалын тухай хуулийн 16.4, энэхүү гэрээний 7.2.3-т заасны дагуу даатгагч нь хуульд заасан хугацаанд даатгалын хохирол үнэлэгчийг томилоогүй бол даатгуулагч нь Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 3.2.4-т заасан даатгалын хохирол үнэлэгч этгээдэд хандах.

8.2. Даатгуулагч дараах үүрэг хүлээнэ:

8.2.1. даатгалын хураамжийг хууль болон гэрээнд заасан хэмжээгээр даатгагчид бүрэн төлөх;

8.2.2. даатгал хийлгэхтэй холбоотой баримт материалыг даатгагчид үнэн зөв гаргаж өгөх;

8.2.3. жолоочийн даатгалд даатгуулсан тухайгаа хохирогчид мэдэгдэх;

8.2.4. зам тээврийн ослын үед ослын газраас хөдлөхгүйгээр даатгалын тохиолдол гарсан талаар даатгагч, цагдаагийн байгууллагад мэдэгдэх, даатгалын гэрээг шалгуулах;

8.2.5. даатгалын тохиолдол болон нөхөн төлбөрийн хэмжээг тогтооход шаардлагатай мэдээллийг даатгагчийн болон эрх бүхий этгээдийн шаардсан хугацаанд гаргаж өгөх;

8.2.6. даатгагч нь дампуурсан бол шуурхай албанд болон шаардлагатай тохиолдолд цагдаагийн байгууллагад мэдэгдэх.

8.3. Тээврийн хэрэгслийн өмчлөгчөөс бусад жолооч нь энэ гэрээний 8.2.3-8.2.6-д заасан үүргийг хүлээнэ.

8.4. Даатгалын тохиолдлын улмаас учирсан хохирлыг тухайн даатгалын тохиолдол гарсан даруйд нөхөн төлөхөөр жолооч хохирогчтой тохиролцсон бол энэ тухайгаа даатгагчид мэдэгдэх бөгөөд даатгагчаас эргэн төлүүлэхээр даатгагчийн зааврын дагуу хохирлыг жолооч барагдуулж болно.

8.5. Даатгуулагч Жолоочийн даатгалын тухай хуулийн 13.1, 13.4 болон энэ гэрээний 8.2.3-8.2.6, 8.5-д заасан үүргээ хүндэтгэх шалтгаангүйгээр биелүүлээгүйн улмаас үүсэх үр дагаврыг даатгагч хариуцахгүй бөгөөд хохирлыг даатгуулагч өөрөө хариуцна.

Ес. Даатгалын нөхөн төлбөр олгох, олгохоос татгалзах нөхцөл

9.1. Даатгагч даатгалын тохиолдлын дуудлага хүлээн авч шалгахдаа Жолоочийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасныг үндэслэнэ.

9.2. Хохирогчийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлын хэмжээг тодорхойлоход Жолоочийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлд, даатгагч нь хохирогчид олгох нөхөн төлбөрийн хэмжээг тогтоож, нөхөн төлбөр олгоход тус хуулийн 19 дүгээр зүйлд заасныг тус тус үндэслэнэ.

9.3. Даатгагч нь Жолоочийн даатгалын тухай хууль болон энэ гэрээнд заасан нөхцөлийн дагуу дараах баримтыг үндэслэн нөхөн төлбөрийг олгоно:

9.3.1. даатгалын гэрээ;

9.3.2. даатгуулагчийн өргөдөл;

9.3.3. шаардлагатай тохиолдолд эрх бүхий этгээдээс учирсан хохирлын талаар бичгээр гаргасан дүгнэлт;

9.3.4. холбогдох бусад баримт бичиг.

9.4. Дараах хохирол жолоочийн даатгалын тохиолдолд үл хамаарна гэж үзэн даатгагч нөхөн төлбөр олгохоос татгалзана:

9.4.1. сэтгэл санааны хохирол;

9.4.2.хүрээлэн байгаа орчныг бохирдуулснаас үүссэн хохирол;

9.4.3.даатгуулагчийн автотээврийн хэрэгсэл, ачаанд учирсан хохирол;

9.4.4.Жолоочийн даатгалын тухай хууль болон энэ гэрээнд заасан хэмжээнээс илүү гарсан хохирол.

Арав. Нөхөн төлбөрийг буцаан нэхэмжлэх үндэслэл

10.1.Даатгагч нь дараах тохиолдолд хохирогчид олгосон нөхөн төлбөрийг буруутай этгээдээс буцаан нэхэмжлэх эрхтэй:

10.1.1.хохирогчид хохирол учирсан нь даатгуулагчийн гэм буруутай холбогдолгүй болох нь хуульд заасан эрх бүхий этгээдийн дүгнэлт, шийдвэрээр тогтоогдвол тухайн буруутай этгээдээс;

10.1.2.даатгалын тохиолдол гарсан талаар Жолоочийн даатгалын тухай хуулийн 13.1, 13.2-т заасан этгээдэд мэдэгдээгүй бол даатгуулагч, жолоочоос;

10.1.3.даатгуулагч нь даатгалын тохиолдол болсон газраас зугтаасан бол тухайн даатгуулагчаас;

10.1.4.даатгуулагч нь согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн үедээ даатгалын тохиолдол гаргасан бол даатгуулагчаас;

10.1.5.хуульд заасан бусад тохиолдолд буруутай этгээдээс.

Арван нэг. Гэрээг дүгнэх, цуцлах нөхцөл

11.1.Энэхүү гэрээ нь дараахь тохиолдолд дуусгавар болно:

11.1.1.гэрээгээр тогтоосон хугацаа дуусгавар болсон;

11.1.2.даатгагч, даатгуулагчийн аль нэг нь дампуурсан, татан буугдсан;

11.1.3.талууд харилцан тохиролцож гэрээг цуцалсан.

Гэрээ байгуулсан:

Даатгагчийг төлөөлж:

Даатгуулагч:

Гарын үсэг: _____

Гарын үсэг: _____

(тамга, тэмдэг)

(тамга, тэмдэг)

Албан тушаал: _____

Албан тушаал: _____

Хаяг: _____

Хаяг: _____

Утас: _____

Утас: _____

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ХУРАЛДААНААР
ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС**

Шийдвэрийн
төслийн нэр:

“Журам, загвар, маягт”-ыг шинэчлэн батлах тухай

	Гарын үсэг:	Албан тушаал, нэр	Огноо:
Зөвшөөрсөн:	СЗХ-ны дарга Д.Баярсайхан
Танилцсан:	СЗХ-ны гишүүн, дэд дарга Т.Цэрэнбадрал
	СЗХ-ны гишүүн, дэд дарга Н.Хүдэрчулуун
Хянасан:	Ажлын албаны дарга Т.Жамбаажамц
	Хууль эрх зүйн хэлтсийн дарга Ж.Мөнх-Оргил
	Даатгалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Батболд
	Даатгалын газрын ахлах референт Н.Батцэцэг
Төсөл боловсруулсан	Даатгалын газрын ахлах мэргэжилтэн О.Бямбасүрэн
Төслийг хүлээн авч, олшруулахыг зөвшөөрсөн:	Захиргаа удирдлагын газрын ахлах зөвлөх Д.Гэрэлчулуун

Санал:

<i>Санал 1</i>	<i>Санал 2</i>	<i>Санал 3</i>

Гарын үсэг, огноо

.....

Гарын үсэг, огноо

.....

Гарын үсэг, огноо

.....